



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/356

Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт, төсвийн
хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дахь заалт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын XVII.3.20 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж” төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын жагсаалт, төсөвт өртөг, 2022 онд санхүүжих хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

3. Төлөвлөгдсөн бараа, ажил, үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Базар)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 10
дугаар сарын 18- өдрийн А/376 дугаар
захирамжийн хавсралт



ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ, ТӨСӨВТ ӨРТӨГ
2022 ОНД САНХҮҮЖИХ ДҮН

№	Зардлын утга	Нийт үнэ	2022 онд санхүүжих
1	Хүнсний ногоо даршлах тоног төхөөрөмж	100.000.000	20,000,000
2	Газар тариаланд ашиглах дугуйт трактор, тоног төхөөрөмж иж бүрдэл /2ш/	200.000.000	40,000,000
	НИЙТ	300,000,000	60,000,000

_____оОо_____